



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ-УС ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/01/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 260512 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Хүлэгтхүннү аудит ХХК-ийн
Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа
Утас: 99100064 Цахим хаяг: gurragchaa@hulegthunnu.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Залруулсан алдаа	17
8.2 Албан шаардлага	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албат татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ-УС ТӨААТҮГ -ЫН
ЗАХИРАЛ Г.БИЛЭГСАЙХАН
ТАНАА

2022.03.15 № 07/552
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд цар тахлын нөхцөл байдлын улмаас Монгол-Унгарын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Унгарын хөнгөлөлттэй зээлээр тус улсын Мечекерц ТӨХК-тай хамтран усны нөөцийн аудит хийх, Усны газартай хамтарч бохир усны зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлох шинжилгээ хийх, усны эрэл хайгуул хийх, ашиглалтын цооногийн өрөмдлөгийн болон шавхалт туршилтын ажил хэрэгжээгүй хойшилж төлөвлөсөн орлого 2,070.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монгол-Ус ТӨААТҮГ-ын тайлант онд нийт 2,198.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,062.5 сая төгрөгийн зардал гарган, 135.6 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 127.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,250.8 сая төгрөгийн зардал гаргаж, 1,123.0 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажиллажээ.

Цэвэр агаар сангийн санхүүжилтээр 2011-2013 онуудад Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан 947.0 сая төгрөгийн худгийн байгууламжийг Төрийн өмчийн хорооны 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 3/594 тоот зөвшөөрлөөр тус үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан бөгөөд тайлант оны эцэст хийсэн дахин үнэлгээгээр уг байгууламж нь 105.8 сая төгрөгөөр үнэлэгдсэн байна. Уг хөрөнгийг анх төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу төрийн өмчийн дансыг нэмэгдүүлж хүлээн зөвшөөрч бүртгэсэн бөгөөд 717.6 төгрөгийн үнэ цэнийн бууралтыг эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	620,232,325.33	282,716,342.67
1.1.2	Дансны авлага	4,796,990.43	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,622,094.24	4,566,971.18
1.1.4	Бусад авлага	-	619,594.48
1.1.6	Бараа материал	22,179,427.40	67,960,638.72
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	80,631.94
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	649,830,837.40	355,944,178.99
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,383,827,418.45	560,068,631.41
1.2.2	Биет бус хөрөнгө	30,922,900.00	30,922,900.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,414,750,318.45	590,991,531.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,064,581,155.85</u>	<u>946,935,710.40</u>
2	Өр төлбөр ба эзэмшигчийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.2	Цалингийн өглөг	-	287,320.68
2.1.1.3	Татварын өр	-	5,842,836.86
2.1.1.4	НДШ-ийн өглөг	52,500.00	369,061.11
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	27,270.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	52,500.00	6,526,488.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	52,500.00	6,526,488.64
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: -Төрийн өмч	1,705,846,007.29	1,705,846,007.29
2.3.9	Хуримтлагдсан ашиг алдагдал	358,682,648.56	(765,436,785.53)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	2,064,528,655.85	940,409,221.76
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>2,064,581,155.85</u>	<u>946,935,710.40</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,467,873,526.90	115,855,495.20
2	Борлуулсан барааны өртөг	812,097,058.44	161,598,863.00
3	Нийт ашиг (алдагдал)	655,776,468.46	(45,743,367.80)
4	Хүүний орлого	22,374,456.55	11,974,794.52
6	Ерөнхий ба удирдлагын зардал	443,427,231.73	376,251,273.30
7	Бусад зардал	50,500.00	4,799,899.33
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	181,770.09	(1,083.28)
9	Бусад ашиг (алдагдал)	-	(708,165,442.10)
10	Татварын өмнөх ашиг (алдагдал)	234,854,963.37	(1,122,986,271.29)
11	Орлогын татварын зардал	23,485,496.33	1,197,479.45
12	Татварын дараах ашиг (алдагдал)	211,369,467.04	(1,124,183,750.74)
13	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
14	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	211,369,467.04	(1,124,183,750.74)
15	Орлогын нийт дүн	211,369,467.04	(1,124,183,750.74)
16	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,674,923,107.29	168,513,181.52	1,843,436,288.81
Залруулсан үлдэгдэл	1,674,923,107.29	168,513,181.52	1,843,436,288.81
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	211,369,467.04	211,369,467.04
Өмчид гарсан өөрчлөлт	30,922,900.00	-	30,922,900.00
Зарласан ногдол ашиг	-	21,200,000.00	21,200,000.00
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,705,846,007.29	358,682,648.56	2,064,528,655.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	21,201,263.35	21,201,263.35
Залруулсан үлдэгдэл	1,705,846,007.29	379,883,911.91	2,085,729,919.20
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(1,124,183,750.74)	(1,124,183,750.74)
Зарласан ногдол ашиг	-	21,136,946.70	21,136,946.70
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,705,846,007.29	(765,436,785.53)	940,409,221.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,198,875,521.45	137,282,111.91
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,198,875,521.45	115,887,910.91
	Буцаан авсан татвар	-	21,394,201.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	907,177,663.83	486,281,805.81
	Ажиллагчдад олгосон мөнгө	403,029,472.79	251,354,585.37
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	86,330,546.23	60,013,375.72
	Бараа материал худалдан авахад төлсөн	227,141,369.10	58,897,736.35
	Ашиглалтын зардал төлсөн	735,808.00	320,080.96
	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	30,580,819.08	24,163,763.65
	Татварын байгууллагад төлсөн	114,316,613.47	16,297,618.88
	Даатгалын төлбөрт төлсөн	115,830.00	231,660.00
	Бусад мөнгөн зарлага	44,927,205.16	75,002,984.88
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	291,697,857.62	(348,999,693.90)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	22,374,456.55	11,974,794.52
	Хүлээн авсан хүүний орлого	22,374,456.55	11,974,794.52
2.2	Мөнгөн зарлагын дүн	74,104,593.28	490,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	74,104,593.28	490,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(51,730,136.73)	11,484,794.52
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	517.81
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		517.81
3.2	Мөнгөн зарлагын дүн	21,200,000.00	-
	Төлсөн ногдол ашиг	21,200,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,200,000.00)	517.81
	Валютын ханшны зөрүү	181,770.09	(1,601.09)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	218,949,490.98	(337,515,982.66)
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	401,282,834.35	620,232,325.33
6	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	620,232,325.33	282,716,342.67

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	1,490,429.76	2,198,098.00	127,830.29	(2,070,267.71)	5.8
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	1,467,873.53	2,198,098.00	115,855.50	(2,082,242.50)	5.3
	Хүүгийн болон бусад орлого		22,505.73	-	11,974.79		
2	Нийт зардал	мян.төг	1,255,574.79	2,062,540.00	1,250,816.56	(811,723.44)	60.6
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	443,427.24	403,993.50	376,251.27	(27,742.23)	93.1
3	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян.төг	234,854.94	135,557.70	(1,122,986.27)	(1,258,543.97)	
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	211,369.45	122,001.90	(1,124,183.75)	(1,246,185.65)	
5	Төсвийн төлбөрт	мян.төг	215,516.79	170,805.87	76,310.99	(94,494.88)	44.7
	НӨАТ-т	мян.төг	75,805.19	58,330.00	-		
	НДШ-т	мян.төг	86,330.50	76,783.20	60,013.38	(16,769.82)	78.2
	ААНОАТ-т	мян.төг	20,000.00	13,555.77	1,197.48	(12,358.29)	8.8
	ХХОАТ-т	мян.төг	30,542.20	20,488.50	14,714.09	(5,774.41)	71.8
	Бусад татвар хураамжид	мян.төг	2,838.90	1,648.40	386.05	(1,262.35)	23.4
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.86	0.94	0.01	(0.93)	1.1
7	Нийт авлага	мян.төг	7,419.09	-	5,186.57		
8	Нийт өглөг	мян.төг	52.50	-	6,526.49		
9	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян.төг	52.50	-	6,526.49		
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	74,104.59	46,230.00	490.00	(45,740.00)	1.1
11	Ногдол ашиг	мян.төг	21,200.00	18,300.30	21,136.94	2,836.64	115.5
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	34	22	17	5	
13	Нийт цалингийн сан	мян.төг	362,881.65	295,320.00	241,546.01	(53,773.99)	81.8
14	Дундаж цалин	мян.төг	889.42	1,118.64	1,193.10		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Хүлэгтхүннү аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Ичинхорол, аудитын менежер Э.Цолмон, аудиторын туслах О.Ариунтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг гүйцэтгэх захирал И.Гүррагчаа, чанарын хяналтын менежер Е.Оюундэлгэр нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 1/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй бөгөөд байгууллага нь дотоод аудитын чиг үүрэг гүйцэтгэх нэгж болон орон тоогүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын 1,490.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 14.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөр, захиалгат ажлууд цар тахлын нөхцөл байдлын улмаас хойшилсон шалтгаалж орлого, зардал материаллаг дүнгээр төлөвлөгөөнөөс дутуу гүйцэтгэлтэй байгаа тул төлөвлөлтийн үе шатанд тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

Гүйцэтгэлийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 148.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монгол-Ус ТӨААТҮГ-ын зорилго нь стратегийн үнэт баялаг бөгөөд хүн ам, хот суурины хөгжил, улс орны нийгэм, эдийн засгийн бүх салбарын үндсэн хэрэглэгдэхүүн болох усны нөөцийг хамгаалах, чанарыг сайжруулах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, улмаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усны нөөцийг зөв зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх,
- Газрын доорх усны нөөцийг тогтоох, эрэл хайгуул судалгаа хийх,
- Усны чанар стандартад усны шинжилгээ хийх,
- Хүн амын аж ахуй, үйлдвэрийн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох,
- Хяналт мониторингийн иж бүрэн тогтолцоог нэвтрүүлэх,
- Улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн газрын доорх усны ордуудыг ашиглуулах.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол-Ус ТӨААТҮГ-ыг нь Засгийн газрын 2011 оны 335 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу чиг үүргийн давхардлыг арилгаж, Усны газарт зарим чиг үүрэг шилжсэнтэй холбоотойгоор 1 хэлтэс татан буугдаж, орон тоог 16 хувиар бууруулсан, цалин хөлсийг нэмэгдүүлээгүй, урамшуулал олгоогүй, зайлшгүй шаардлагатай гарах зардлаас бусад зардлуудыг хэмнэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Усны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт,
- Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүд,
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”,
- Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоол “Төлөвлөгөө батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдал, орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	620,232.4	282,716.4	(337,516)
Авлага	7,419.1	5,186.6	(2,232.5)
Бараа материал	22,179.4	67,960.6	45,781.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	80.6	80.6
Үндсэн хөрөнгө	1,383,827.4	560,068.6	(823,758.8)
Биет бус хөрөнгө	30,922.9	30,922.9	-
Нийт хөрөнгийн дүн	2,064,581.2	946,935.7	(1,117,645.5)
Өр төлбөр	52.5	6,526.5	6,474.0
Эздийн өмч	2,064,528.7	940,409.2	(1,124,119.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,064,581.2	946,935.7	(1,117,645.5)

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд цалингийн зөрүү тушааснаас орсон 0.6 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Банк дахь харилцах дансны нийт 282.1 сая төгрөгийн үлдэгдлийн байршуулснаас 277.7 сая төгрөг нь төгрөгийн үлдэгдэл, 4.4 сая төгрөг нь ам.долларын үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 5.2 сая төгрөг болж, 2.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх тайлант онд үүссэн 4.9 сая төгрөгийн ажилчдаас авах авлагыг барагдуулж, тайлант оны худалдан авалтын 1.9 сая төгрөгийн НӨАТ-аар өссөн байна.

Байгууллагын авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн болон найдваргүй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67.9 сая төгрөг болж, 45.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Түмэн Онъс ХХК-иас 49.9 сая төгрөгийн ган хоолой худалдан авснаас шалтгаалжээ.

Тайлант оны дундуур 49.9 сая төгрөгийн ган хоолойн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь тайлант жилд хугацаа хойшилсон усны эрэл хайгуул, ашиглалтын цооногийн өрөмдлөгийн ажилтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нь Туул голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан худгийн барилгын дахин үнэлгээний үнэ цэнийн өсөлт 9.4 сая төгрөгөөр нэмэгдэж, Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан худгийн барилгын дахин үнэлгээний үнэ цэнийн 717.6 сая төгрөгийн бууралтаар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 1/55 дугаар албан тоотоор 8.1 сая төгрөгийн акталсан үндсэн хөрөнгийг акталсан дүн, тайлант жилд байгуулсан 107.5 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр тус тус буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдлийн 5.8 сая төгрөг нь ХХОАТ-ын өглөг, 0.4 сая төгрөг нь НДШ-ийн өглөг, үлдсэн 0.3 сая төгрөг нь ажилчдад өгөх өглөг байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол-Ус ТӨААТҮГ үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 646 дугаар тогтоолоор Монгол - Ус ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,198.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,062.5 сая төгрөгөөр, 135.6 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 46.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 127.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,250.8 сая төгрөгийн зардал гарган, 1,123.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 127.8 сая төгрөг болж төлөвлөсөн орлогоос 2,070.3 сая төгрөг буюу 94 хувиар тасарсан, нийт зардлын гүйцэтгэл 1,250.8 сая төгрөг болж, төлөвлөсөн зардлаас 811.7 сая төгрөг буюу 61 хувиар дутуу гүйцэтгэлтэй, 135.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөснөөс 1,123.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан зэрэг нь цар тахлын нөхцөл байдлын улмаас тайлант онд хэрэгжих Монгол-Унгарын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Унгарын хөнгөлөлттэй зээлээр тус улсын Мечекерц ТӨХК-тай хамтран усны нөөцийн аудит хийх, Усны агентлагтай хамтарч бохир усны зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлох шинжилгээ хийх, усны эрэл хайгуул хийх, ашиглалтын цооногийн өрөмдлөгийн болон шавхалт туршилтын ажил хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Тайлант онд 21.1 сая төгрөгийн ногдол ашиг буюу ашгийн 10 хувийг төвлөрүүлэхээс 21.1 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

Нийт 1,250.8 сая төгрөгийн зардлаас 161.6 сая төгрөг нь үйлчилгээний өртөг, 376.2 сая төгрөг нь ерөнхий удирдлагын зардал, үлдсэн 713.0 сая төгрөг нь үйл ажиллагааны бус зардал тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад үйлчилгээний өртөг 650.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын захиалгаар хийгдэх төсөл хөтөлбөрийн ажлууд цар тахлын улмаас хойшлогдон, холбогдох зардлууд гараагүйгээс шалтгаалсан бол үйл ажиллагааны бус зардал 708.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хийгдсэн Туул болон Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан худгийн байгууламжийн дахин үнэлгээний үнэ цэнийн бууралтаас шалтгаалсан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цалин, нийгмийн даатгал, элэгдэл, лабораторийн хангамжийн материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлуудыг хамруулсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол-Ус ТӨҮГ нь тайлант онд нийт 211.0 сая төгрөгийн 18 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5.6 сая төгрөгийн 1 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн, ил тод байршуулах талаар зөвлөмж өгөх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд цар тахлын нөхцөл байдлын Монгол-Унгарын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Унгарын хөнгөлөлттэй зээлээр тус улсын Мечекерц ТӨХК-тай хамтран усны нөөцийн аудит хийх, Усны газартай хамтарч бохир усны зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлох шинжилгээ хийх, усны эрэл хайгуул хийх, ашиглалтын цооногийн өрөмдлөгийн болон шавхалт туршилтын ажил хэрэгжээгүй хойшилж төлөвлөсөн орлого 2,070.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид санхүүгийн төлөвлөгөөгөө бодитой боловсруулж, биелэлтийг ханган ажиллах талаар албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн, бусад хууль тогтоомж хүрээнд шалгасан орлогын тасралт нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,054.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 3.6 сая төгрөгийг залруулж, 1,049.8 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 0.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 109.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс төлбөрийн акт 100 хувь, зөвлөмж 33.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	312.0	1	312.0	0	0.0	100.0
Зөвлөмж	3	109,281.8	1	0.0	2	109,281.8	33.0
Нийт дүн	4	109,593.8	2	312.0	2	109,281.8	66.5

Нийт аудитын илрүүлэлтээс элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн дахин үнэлгээ болон программтай холбоотой 109.3 сая төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Алдаа, зөрчил давтан гарсан асуудалд 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 766.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 766.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчил нь тогтоосон 1.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 766.1 сая төгрөгийн 14 алдааг залрууллаа. Үүнд:

1. Өмнөх оны аудитын залруулгыг санхүүгийн тайланд залруулж, тайлагнасан боловч татварын тайланг засаж илгээгүйгээс татварын тодорхойлолтоор үлдэгдлээс ААНОАТ-ын авлагын үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр, ХХОАТ-ын өглөгийн үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй алдааг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг руу бүртгэж,
2. Санхүүгийн тайланд толилуулсан НӨАТ-ын авлагын үлдэгдэл нь борлуулалтын орлого дутуу ногдуулсан 0.2 сая төгрөгөөр, НӨАТ-гүй худалдан авалтын татварыг салгаж бүртгэсэн 0.6 сая төгрөгөөр тус тус илүү, 2017 оноос өмнө үүссэн, зөрсөн шалтгаан нь тодорхойгүй 0.6 сая төгрөгөөр, НӨАТ-тай худалдан авалтын НӨАТ-ын авлагыг бүртгээгүй 0.2 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн алдаануудыг холбогдох дансдад,
3. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 0.8 сая төгрөгөөр дутуу, 0.3 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн алдааг хуримтлагдсан ашиг, хуримтлагдсан элэгдлийн дансанд,
4. Туул болон Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан худгийн байгууламжийн 708.2 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтын гарзыг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг руу бүртгэсэн тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч,
5. Байгууллагын санхүүгийн тайланд толилуулсан 30.9 сая төгрөгийн газар эзэмших эрхийг Усны газартТӨБЗГ-ын тогтоол гараагүй байхад газар эзэмших эрхийг данснаас хассаныг буцаах бичилт хийж,
6. Өмнөх тайлант жилд татвараас авах авлага үүсгэж бүртгээгүй 21.1 сая төгрөгийн ААНОАТ-ын буцаалтыг тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрснийг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг руу бүртгэж,
7. ХХОАТ-ыг суутгахдаа нэр бүхий 3 ажилтнаас 0.2 сая төгрөгөөр дутуу, 1 ажилтнаас 0.3 сая төгрөгөөр илүү суутгаж, цалинг олгосон алдааг холбогдох ажилтанд авлага, өглөг үүсгэж,
8. Нэр бүхий ажилтанд цалинг 0.1 сая төгрөг, түүнээс тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг 0.3 сая төгрөгөөр тус тус илүү тооцож, цалинг олгосон холбогдох ажилтанд авлага үүсгэж,
9. Нэр бүхий ажилтанд цалинг нөхөн олгохдоо гарт олгосон дүнгээр хуримтлагдсан ашиг руу хүлээн зөвшөөрч бүртгэснийг цалингийн зардлаар, 1.3 сая төгрөгийн цалингийн зардал, 0.3 сая төгрөгийн НДШ-ийн өглөг, 0.1 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг тус тус хүлээн зөвшөөрч бүртгээгүй алдааг зардал, өглөгөөр бүртгэж, нөхөн тайлан бэлтгэх зөвлөмж өгч,
10. Программын зөрүүнээс шалтгаалан үүссэн бараа материалын хяналтын тооллогоор 0.1 сая төгрөгийн дутагдал үүссэн аудитын явцад хуримтлагдсан ашиг дансанд,

11. Хүүгийн орлогоос тооцсон 1.2 сая төгрөгийн орлогын албан татварын зардлыг удирдлагын зардлаар хүлээн зөвшөөрсөн удирдлагын зардлыг буцаан, орлогын албан татварын зардалд бүртгэж тус тус залруулав.

8.2 Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Цэвэр агаар санг санхүүжилтээр 2011-2013 онуудад Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан 947.0 сая төгрөгийн худгийн байгууламжийг Төрийн өмчийн хорооны 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 3/594 тоот зөвшөөрлөөр тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан бөгөөд тайлант онд хийсэн дахин үнэлгээгээр уг байгууламж нь 105.8 төгрөгөөр үнэлэгдэн 717.6 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтын гарз үүссэн. Үнэ цэнийн бууралтын асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

8.3 Албан шаардлага

1. Санхүүгийн программд санхүүгийн тайлан, бараа материалын товчоо тайлан зөрүүтэй бэлтгэгдэг алдааг программ хийсэн компанидаа хандан засуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Санхүү, бүртгэлийн программын бараа материалын модуль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцээгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй, Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ..4.2.1.10.аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 109.3 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг дахин үнэлүүлээгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь НББОУС 16 Үндсэн хөрөнгийн 31-д "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Тайлагналын үеийн эцэс дэх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино.", 34-т "Дахин үнэлгээ хийх давтамж нь уг дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаардаг. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллагаар өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай. Үнэ цэнэд нь ялимгүй бага өөрчлөлт ордог үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд ... гурав буюу таван жил тутам дахин үнэлэх шаардлагатай байж болно.", Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ...4.2.1.10 аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж тус тус заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд толилуулсан НӨАТ-ын авлагын үлдэгдэл нь борлуулалтын орлого дутуу ногдуулсан 23.8 мянган төгрөгөөр, НӨАТ-гүй худалдан авалтын татварыг салгаж бүртгэсэн 579.3 мянган төгрөгөөр тус тус илүү, 2017 оноос өмнө үүссэн, зөрсөн шалтгаан нь тодорхойгүй 574.1 мянган төгрөгөөр, НӨАТ-тай худалдан авалтын НӨАТ-ын авлагыг бүртгээгүй 182.7 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн байна.	Санхүүгийн тайланд НӨАТ-ын авлага залруулав	1	1,360.0	1	1,360.0									
2	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Өмнөх оны аудитын залруулгыг санхүүгийн тайланд залруулж, тайлагнасан боловч татварын тайланг засаж илгээгүйгээс татварын тодорхойлолтоор үлдэгдлээс ААНОАТ-ын авлагын үлдэгдэл 31.2 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын өглөгийн үлдэгдэл 25.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	Санхүүгийн тайланд авлага залруулав	1	56.2	1	56.2									
3	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Бараа материалын хяналтын тооллогоор 102.8 мянган төгрөгийн дутагдал үүссэн.	Санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдэл залруулав	1	102.8	1	102.8									

4	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 109,281.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг дахин үнэлүүлээгүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	ТӨБЗГ-аас зөвшөөрлийг авч, хөрөнгийг дахин үнэлүүлж, үр дүнг нь санхүүгийн тайланд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөх	1														
5	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Санхүүгийн программд санхүүгийн тайлан, бараа материалын товчоо тайлан зөрүүтэй бэлтгэгдэг алдааг программ хийсэн байгууллагадаа хандан засуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	Санхүүгийн программд санхүүгийн тайлан, бараа материалын товчоо тайлан зөрүүтэй бэлтгэгддэг алдааг программ хийсэн байгууллагадаа хандан засуулах, алдааг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөх	1	11.4					1	11.4							
6	М1онгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Туул болон Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан худгийн байгууламжийн 708,165.4 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтын гарзыг тайлант оны алдагдлаар бүртгээгүй, өмнөх үеийн хуримтлагдсан ашиг руу бүртгэсэн байна.	Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ залруулав.	1	708,165.4	1	708,165.4											
7	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 795.7 мянган төгрөгөөр дутуу, 274.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.	Санхүүгийн тайланд элэгдлийг залруулав.	1	1,070.0	1	1,070.0											
8	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Байгууллагын санхүүгийн тайланд толилуулсан 30,922.9 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг Усны газар руу шилжүүлэн өгөхөөр ТӨБЗГ-аас	Санхүүгийн тайланд газар эзэмших эрхийг залруулав.	1	30,922.9	1	30,922.9											

			шийдвэрлэсэн бөгөөд ТӨБЗГ-ын тогтоол гараагүй боловч газар эзэмших эрхийг данснаас хасч бүртгэсэн байна.															
9	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Өмнөх тайлант жилд татвараас авах авлага үүсгэж бүртгээгүй 21,108.9 мянган төгрөгийн ААНОАТ-ын буцаалтыг тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	Санхүүгийн тайланд орлого залруулав	1	21,108.9	1	21,108.9										
10	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	ХХОАТ-ыг суутгахдаа нэр бүхий 3 ажилтнаас 196.7 мянган төгрөгөөр дутуу, 1 ажилтнаас 27.3 мянган төгрөгөөр илүү суутгаж, цалинг олгосон байна.	Санхүүгийн тайланд цалингийн зардал залруулав.	1	224.0	1	224.0										
11	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Нэр бүхий ажилтанд цалинг 130.9 мянган төгрөг, түүнээс тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг 24.7 мянган төгрөгөөр тус тус илүү тооцож, цалинг олгосон байна.	Санхүүгийн тайланд цалинг залруулав.	1	155.6	1	155.6										
12	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Нэр бүхий ажилтанд цалинг нөхөн олгохдоо гарт олгосон дүнгээр хуримтлагдсан ашиг руу хүлээн зөвшөөрч бүртгэж, 1,282.3 мянган төгрөгийн цалингийн зардал, 305.8 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг, 120.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг тус тус хүлээн зөвшөөрч бүртгээгүй, холбогдох тайлангуудад тайлагнаагүй байна.	Санхүүгийн тайланд цалинг залруулав.	1	1,708.9	1	1,708.9										
13	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	Хүүгийн орлогоос тооцсон 1,197.5 мянган төгрөгийн орлогын албан татварын зардлыг удирдлагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	Санхүүгийн тайланд зардал залруулав	1	1,197.5	1	1,197.5										
14	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/НА-СТА-ТӨА	"Цэвэр агаар сан"-ийн санхүүжилтээр 2011-2013 онуудад Сэлбэ голын урсцыг байгалийн аясаар нөхөн	Хөрөнгийн үнэ цэнийн бууралт юунаас шалтгаалан буурсныг хуулийн	1												1	

			сэргээх, нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан 947,000.0 мянган төгрөгийн худгийн байгууламжийг Төрийн өмчийн хорооны 2014 оны 03 сарын 04-ний өдрийн 3/594 тоот зөвшөөрлөөр тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан бөгөөд тайлант онд хийсэн дахин үнэлгээгээр уг байгууламж нь 105,814.6 мянган төгрөгөөр үнэлэгдсэн. Уг хөрөнгийг анх ТӨБЗГ-аас хүлээн авахдаа төрийн өмчийн дансыг нэмэгдүүлж хүлээн зөвшөөрч бүртгэсэн бөгөөд 717,641.0 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтыг эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй байна.	байгууллагаар тодорхойлуулах, холбогдох эрх бүхий байгууллагаар эздийн өмчид өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг шийдвэрлүүлэх														
			ДҮН		14	766,083.6	11	766,072.2			2	11.4	1					
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	Монгол-Ус ТӨААТҮГ	АХГ-2022/01/Н А-СТА-ТӨА	Шилэн дансанд байршуулах мэдээллээс "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ"-ний хэсэгт мөнгөн орлогын 5,646.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.	Цаашид шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн, ил тод байршуулах	1	5,646.0											1	5,646.0
2			Нийт орлогын гүйцэтгэл 2,070,267.7 мянган төгрөг буюу 94.2 хувиар тасарсан байна.	Цаашид санхүүгийн төлөвлөгөөгөө бодитой боловсруулж, биелэлтийг ханган ажиллах	1	2,070,267.7					1	2,070,267.7						
			ДҮН		2	2,075,913.7	-	-			-	-					1	5,646.0
			НИЙТ ДҮН		16	2,841,997.3	11	766,072.2			3	2,070,279.1	1				1	5,646.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 479/20150054

Улаанбаатар хот

АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 109,281,765.29 төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, санхүүгийн программд санхүүгийн тайлан, бараа материалын товчоо тайлангаас 11,363.63 төгрөгөөр зөрүүтэй бэлтгэгдсэн алдааг программ хийсэн компанидаа хандан засуулаагүй, санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг тус тус хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь НББОУС 16 Үндсэн хөрөнгийн 31-д "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Тайлагналын үеийн эцэс дэх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, Санхүүгийн программын алдааг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол-Ус ТӨААТҮГ-ын захирал Г.Билэгсайхан, Ерөнхий нягтлан бодогч В.Сэлэнгэ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХҮЛЭГТХҮННУ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ч.ИЧИНХОРОЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-174.Docx

0001081343



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 480/20150054

Улаанбаатар хот

АХГ-2020/03/НА-СТА-ТӨААТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Монгол-Ус ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшний төлөвлөгөөнд туссан нийт орлогын гүйцэтгэл 2,070,267,710.28 төгрөг буюу 94.2 хувиар тасарсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол-Ус ТӨААТҮГ-ын захирал Г.Билэгсайхан, Ерөнхий нягтлан бодогч В.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ч.ИЧИНХОРОЛ

